



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 423

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, түүний харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 4 нэрийн 108,421,440.00 (нэг зуун найман сая дөрвөн зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун дөчин) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 22,500,000.00 (хорин хоёр сая таван зуун мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 08 дүгээр сарын 08-ны өдрийн
403 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН, ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон он	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Шилжүүлэн авах хуулийн этгээд
					Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)		
1.Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн									
1	Хьюндай старекс 04-22ДАР /арал-KMFVWVH7HP7U776227	2007	1	13,847,032.00	1	4,500,000.00	4,500,000.00	2	Дархан-Уул аймгийн Шүүхийн шинжилгээний алба
	Дүн			13,847,032.00	1	4,500,000.00	4,500,000.00		
2. Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар									
2	Хьюндай старекс 02-64 УНЛ /тусгай зориулалт, арал-KMFVWBH7JP9U084418/	2009	1	39,600,000.00	1	5,000,000.0	5,000,000.0	2	Говьсүмбэр аймгийн Шүүхийн шинжилгээний алба
	Дүн			39,600,000.00	1	5,000,000.0	5,000,000.0		
3.Хэнтий амйгийн Шүүхийн шинжилгээний хүрээлэн									
3	Фотон 09-68 УНУ /тусгай зориулалт, арал-lvcb2nbad8ds070725/	2013		32,374,408.00		3,000,000.00	3,000,000.00	3	Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба

	Дүн				32,374,408.00		3,000,000.00	3,000,000.00	
4.Увс аймгийн Шүүхийн шинжилгээний газар									
4	УАЗ Фургон 16-86 УВХ /арал-374100D0413313/	2013			22,600,000.00		10,000,000.0	10,000,000.0	Завхан аймгийн Шүүхийн шинжилгээний алба
	Дүн				22,600,000.00		10,000,000.0	10,000,000.0	
	Нийт дүн				108,421,440.00 (нэг зуун найман сая дөрвөн зуун мянга дөрвөн зуун дөчин)		22,500,000.00 (хорин хоёр сая таван зуун мянган)		